

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
2017 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

**Цаг уур, орчны шинжилгээний газар /байгууллагын нэр/
Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, 51-264913,
96727353 /тодруулга өгөх албан тушаалтан, холбоо барих утас/
2018-01-19 / огноо/**

№	Хөтөлбөрийн танилцуулга хэсэг	
1.	Хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”
2.	Хөтөлбөрийн зорилго	Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх
3.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламжийн хөрөнгө
4.	Хэрэгжүүлэгч байгууллага	Бүх шатны төрийн байгууллага
5.	Хэрэгжих нийт хугацаа	6 жил
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1. шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;</p> <p>Зорилт 2. төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p>Зорилт 3. төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p>Зорилт 4. худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх;</p>

Зорилт 5. шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах;

Зорилт 6. авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх;

Зорилт 7. авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих;

Зорилт 8. иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх;

Зорилт 9. улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах;

Зорилт 10. шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх;

Зорилт 11. авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх.

7.	Зардал	Төсөв	24,962.4	
		Үүнд:	Төсөв	Гүйцэтгэл
		1-р үе шат	14,308.9	499.0
		2-р үе шат	10,653.5	-

Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах хэсэг

8.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Гүйцэтгэлийг Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан төлөвлөгөөний арга хэмжээ бүрээр, хүрсэн түвшин, үр дүнгийн үзүүлэлтийн хамт зохих талбарт бичнэ.
	1-р зорилтын хүрээнд:	1. Төрийн захиргааны /ТЗ-5-аас дээш/ болон төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтнууд /ТҮ-10-аас дээш/, ахлах нягтлан бодогч нарыг томилохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг хянуулж, уг албан тушаалд томилоход ашиг сонирхолын зөрчилгүй болохыг мэдэгдсэн албан бичиг ирсний дараа томилгоог хийж байсан. Хэнтий, Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газарт ХАСУМ хянуулах албан тушаалтныг хянуулаагүй томилсон байсныг мэдмэгцээ албан тушаалаас чөлөөлүүлж, ХАСУМ хянуулахыг шаардсан. Үүний дагуу уг

байгууллагууд зөрчлийг арилгаж ажилласан. 2017 онд ЦУОШГ-аас

-Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны 3-н ажлын байранд нийт 5-н нэр дэвшигчийн материалыг АТГ-т хянуулсан.

-Төрийн захиргааны 3 албан тушаалд 3 нэр дэвшигчийн материал АТГ-т хянуулсан.

2. Төрийн алба хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг үнэн зөв оруулж ажиллаж байна. Цаг уур орчны шинжилгээний газар нь 2017 онд 5 хэлтэстэй ажилласан. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланд 79 албан хаагч бүртгэгдсэн. Үүнээс төрийн захиргааны албан хаагч 21, бусад нь төрийн үйлчилгээний албан хаагч 58 байна. Хүйсийн хувьд 31 эрэгтэй, 48 эмэгтэй албан хаагч ажиллаж байна. Үүнээс 1 албан хаагч Япон улсад магистрын сургалтанд, 1 албан хаагч докторын сургалтанд суралцаж түр чөлөө олгосон. 5-н албан хаагч хүүхэд асрах чөлөө авсан.

2017 онд тус газарт гарсан 10-н сул орон тоог дараах байдлаар сонгон шалгаруулж авсан. Үүнд

*5 албан тушаалтныг харьяа байгууллагаасаа сонгон шалгаруулж авсан. Дараах шалгуур үзүүлэлтүүдийг тавьж сонгон шалгаруулсан.

- уг албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг албан тушаалтан байх

- тухайн мэргэжилээр мэргэшсэн байх

-орон нутгаа хариуцаад, заавар зөвөлгөө өгч ажилладаг байх

*Туслах үйлчилгээний ажилтан 1-ыг ажилд авсан. Байгууллагын сайтад, зарын самбарт зарлал байрлуулж, ирсэн анкеттай танилцаж, ярилцлага хийж сонгон шалгаруулж авсан.

*Нарийн мэргэжил шаардсан төрийн үйлчилгээний 4 ажлын байранд нөөцөд бүртгэлтэй байсан хүмүүсийн анкетнаас, ярилцлаганаас сонгон шалгаруулалт хийж, туршилтын 3 сарын хугацаатай ажилд авсан.

3. 2.Албан хаагчдын 2017 оны ажлыг хагас болон бүтэн жилээр дүгнэж ажилласан. Мөн албан хаагчдын ажлын ачаалал, цаг ашиглалт, ажлын байрны тодорхойлолтын зорилт, үйл ажиллагааны зорилтын хэрэгжилт, тайланг шалгах, үнэн зөв дүгнэж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор газрын даргын 2017 оны А/84 тушаалаар ажлын хэсгийг байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Архив мэдээллийн сангийн хэлтсийн ажлыг шалгаж, хэлтсийн даргыг удирдлагаар хангаж ажиллах үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж дүгнэж, ажил сайжруулах хугацаатай үүрэг өгч ажиллалаа. Цаашид бусад хэлтсүүдийг үргэлжлүүлэн

		<p>шалгахаар төлөвлөөд байна.</p> <p>4. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын удирдах ажилтны семинар, сургалтад Авилгатай тэмцэх газраас мэргэжилтэн урин авчирч, ХАСУМ, ХАСХОМ, Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх асуудлаар мэдэгдэл гаргахад анхаарах асуудлуудаар сургалт зохион байгуулсан.</p> <p>Авилгатай тэмцэх газраас 4 сард ажлын хэсэг ирж ажиллахад шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж ажилласан. Ажлын хэсэг Авилгын эсрэг үндэсний хөтөлбөрийг нийт албан хаагчдад таниулах лекц уншсан.</p> <p>5.Төрийн албаны тухай хуулийн 23.2, 23.4-оор ажлаас чөлөөлөгдсөн албан тушаалтан байхгүй.</p>
2-р зорилтын хүрээнд:		<p>1. http://www.namem.gov.mn байгууллагын сайтад “Авилгын эсрэг үйл ажиллагааны ил тод байдал” хэсэгт дараах мэдээллүүдийг оруулсан.</p> <ul style="list-style-type: none"> *Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр *Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө *Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйл. Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт * Авилгад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалт * Нийтийн албан тушаалтанд зориулсан гарын авлага * Мэдүүлэг гаргагчдад зориулсан гарын авлага * Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн маягт * Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт <p>2. Мөн байгууллагын авилгад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргаж, газрын даргаар</p>

	<p>батлуулж байгууллагын сайтад байршуулсан.</p> <p>3. Газрын http://namem.gov.mn сайтан дээр АТГ-ын вэб хаяг болон ХАСХОМ рүү шууд орох хаягийг байршуулсан.</p>
<p>3-р зорилтын хүрээнд:</p>	<p>2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг аудитаар батлагаажуулж байгууллагын цахим сайт, болон, шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулсан.</p> <p>“Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”-ийн дагуу салбарын байгууллагуудын сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн дэлгэрэнгүй болон нэгтгэсэн мэдээг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулж байгууллагын www.namem.gov.mn цахим хуудсанд, нэгтгэсэн мэдээг мэдээллийн самбарт байршуулж, хуулийн хугацаанд олон нийтэд мэдээлэв.</p> <p>2017 онд “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоол, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх календарчилсан төлөвлөгөө гаргаж Газрын даргаар батлуулж биелэлтэд нь хяналт тавьж ажиллаа.</p> <p>Харьяа байгууллагуудад “Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай” 2017 оны 04/03-ны 1/259 тоот албан тоот явуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.</p> <p>ЦУОШГазрын даргын 2012 оны 04 дүгээр сарын 26-ны 80 тоот тушаалаар батлагдсан Ус,цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын болон тус газрын төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах, олон нийтэд мэдээллийг хүргэх төлөвлөгөөний дагуу эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсөв, урсгал зардал /зардлын зүйлээр/, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр/төсөв, өөрийн орлого/, батлагдсан орон тоо, худалдан авах ажиллагааны зар, төсөв хөрөнгийн зарцуулалтын мэдээ, худалдан авалтын тайлангуудыг байгууллагын болон шилэн данс болон мэдээллийн самбараар мэдээлж ажилласан.</p>
<p>4-р зорилтын хүрээнд:</p>	<p>УИХ-аас баталсан жилийн төсөв, урсгал зардал, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, өөрийн орлого, батлагдсан орон тоо болон худалдан авах ажиллагааны тайланг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар болон шилэн дансаар хуулийн хугацаанд нийтэд мэдээлсэн.</p> <p>Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын урсгал төсөв, цаг уурын төвлөрсөн арга хэмжээний зардлаар 2017 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ерөнхий</p>

	<p>төлөвлөгөөг БОАЖ-ын сайдаар батлуулж тендерийн мэдээллийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас tender.gov.mn болон байгууллагын цахим хуудас, шилэн данс, ил тодын самбарт байршуулж ажиллаа.</p> <p>2017 оны 1-11 дүгээр саруудын салбарын худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл, шалгарсан аж ахуйн нэгж, нийлүүлсэн барааны үнийн тухай мэдээллийг худалдан авалт бүрээр гаргаж, газрын цахим хуудас, мэдээллийн ил тодын самбар, шилэн дансанд байршуулж нийтэд мэдээлсэн.</p>
5-р зорилтын хүрээнд:	Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газрын дарга асан Отгонбаярыг ашиг сонирхолыг зөрчил үүссэн эсэхийг Авилгатай тэмцэх газарт хянуулсан.
6-р зорилтын хүрээнд:	<p>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр зарлаж, тендерийн урилга, тендерийн шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох цахим хуудсуудаар нээлттэй тавьсан.</p> <p>Тендерт оролцогчидын талаарх мэдээллийг тухай бүр нь гаргаж тендерт шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тухайн оролцсон компани, иргэнд албан тоотоор хариуг хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.</p>
7-р зорилтын хүрээнд:	"Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв"-д 49 иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдолд хариу өгч хаасан.
8-р зорилтын хүрээнд:	Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангаж, нээлттэй, ил тод, хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, шудрагаар ажиллах зарчмыг бүх шатандаа хэрэгжүүлж байна.
9-р зорилтын хүрээнд:	Төсвөөс авсан санхүүжилтаа ил тод тайлагнаж, худалдаж авах ажиллагааг нээлттэй ил тод шудрага явуулж байна. Шилэн дансны хууль тогтоомжийн дагуу ажиллаж байна. Оффшор бүсэд данс эзэмшдэг хүн байхгүй.
10-р зорилтын хүрээнд:	Харьяа байгууллага хамт олонд нийгмийн шудрага ёсны үзэл санааг төлөвшүүлэх, авилгаас ангид байх соён гэгээрүүлэх зорилгоор АТГ болон бусад байгууллагуудтай хамран ажиллаж байна.
9.	Дүгнэлт (ололт, дутагдал, Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон ололттой талуудыг бичнэ.

	анхаарах асуудлууд)	Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон дутагдалтай талуудыг бичнэ. Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон анхаарах асуудлуудыг бичнэ.				
10.	Санал					
11.	Шаардагдах төсөв					
12.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Захиалагч талууд, хэрэгжүүлэгч талууд, санхүүжүүлэгч тал, гүйцэтгэгч талууд хэрхэн хамтарч ажилласан талаар энд бичнэ.				
13.	Сургалтад хамруулах албан хаагчийн тоо	Авлигын эсрэг хууль тогтоомж ба төрийн байгууллагын хүлээх үүргийн талаар 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 10.00-10.45 цагийн хооронд нийт 35-40 хүнд сургалт авахаар албан бичиг АТГ явуулсан.				
Бүх шатны төрийн байгууллагад хамаарах						
14.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		94 %	3	90 %	95 %	98 %
15.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 7	Зорилт 10	-
		93 %	2	95 %	92 %	-
Төрийн зарим байгууллагад хамаарах						
16.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 4	Зорилт 5	Зорилт 6
		94 %	3	98 %	90 %	95 %
17.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 8	Зорилт 9	Зорилт 11
		90 %	3	90 %	90 %	... %
18.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (АТГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ				
		93.3 %				

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР